

**ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧИЙН  
2019 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД  
ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ**

## Агуулга

1. Аудитын гэрчилгээ .....	2
2. Аудитын тайлан.....	4
2.1. Оршил .....	4
2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага.....	4
2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт .....	4
2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин .....	5
2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ .....	5
2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал .....	5
2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар .....	5
2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд .....	6
2.9. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга.....	6
2.10. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн.....	7
2.11. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал .....	7
2.12. Шилэн дансны мэдээлэл.....	7
2.13. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт .....	7
2.14. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл.....	7
3. Менежментийн захидал.....	9
4. Аудит хийсэн санхүүгийн тайлан.....	10
4.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан.....	10
4.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан.....	11
4.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан .....	14
4.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан.....	16
4.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	17
4.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан .....	19
5. Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт .....	20

### Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
БСШУСЯ СӨ	Боловсрол, Соёл, Шинжлэх Ухаан, Спортын Яам Соёлын өв



## ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг  
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр  
Утас:26-04-37, Факс:51-26-42-30  
E-mail: info@audit.gov.mn

СОЁЛЫН ӨВИЙН ҮНДЭСНИЙ  
ТӨВИЙН ЗАХИРАЛ Г.ЭНХБАТ  
ТАНАА

2020-02-27 № 06/62/  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-г

### Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Соёлын өвийн үндэсний төвийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

### Зөрчилгүй санал дүгнэлт

Соёлын өвийн үндэсний төвийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/ өмчийн өөрчлөлт мөнгөн гүйлгээний тайлан болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

### Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Соёлын өвийн үндэсний төвийн 2019 оны оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, тодруулга дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, программ хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.


Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

## Үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-д дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

САНХҮҮГИЙН АУДИТЫН  
ГАЗРЫН ЗАХИРАЛ БӨГӨӨД  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

## **2. Аудитын тайлан**

### **2.1. Оршил**

Соёлын өвийн үндэсний төвийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг захирал Г.Энхбат танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц асуудал, залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчил, тодруулга зэрэг аудитын үр дүн, аудитын дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, тайлагнал, дотоод хяналтын системийг боловсронгуй болгох татварын тайлагналтай холбоотой зөвлөмжийг Менежментийн захидалд тусгасан болно.

### **2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага**

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 15.2, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Соёлын өвийн үндэсний төвийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болгосон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Соёлын өвийн үндэсний төвийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн шууд захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2020 оны 01 дүгээр сарын 29-нээс 2020 оны 02 дугаар сарын 19-ний хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2020 оны 02 дугаар сарын 21-ны өдөр эцэслэн баталгаажуулж, төсвийн шууд захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Эвиденсе аудит ХХК хариуцаж хэрэгжүүлэв.

Соёлын өвийн үндэсний төвийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Эвиденсе аудит ХХК-д 2020 оны 01 дүгээр сарын 31-ний өдрийн 01/13 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

### **2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт**

АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, санхүүгийн тайлангийн аудитад баримтлах ерөнхий чиглэл, арга зүйг мөрдөн ажиллав.

Дээрх стандарт, зарчим, журамд нийцүүлж аудитын үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

## **2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин**

Соёлын өвийн үндэсний төвийн үйл ажиллагааны эрхэм зорилго нь Монголын үндэсний соёлын биет болон биет бус өвийг хамгаалах, бүртгэн баримтжуулах сэргээн засварлах хойч үедээ өвлүүлэн уламжлуулахад оршино.

Соёлын өвийн үндэсний төвийн үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Соёлын өвийн улсын нэгдсэн бүртгэл, мэдээллийн сан бүрдүүлэх, сургалт судалгаа хийх, сурталчлах, түүх соёлын дурсгалыг сэргээн засварлах, соёлын өвийг авран хамгаалах;
- Соёлын өвийг эрэн сурвалжлах, таньж тогтоох, тодорхойлох, бүртгэл баримтжуулах, сурталчлах талаар арга зүйн зөвлөгөө өгөх;
- Соёлын өвийн мэдээллээр гэрэл зургийн цомог, сурталчилгааны хялбаршуулсан бүтээл гаргах, баримтат кино, медиа бүтээл хийж олон нийтэд танилцуулах.

Тайлант хугацаанд Нийгмийн даатгалын шимтгэлийн хувь хэмжээ болон Хувь хүний орлогын албан татварын хөнгөлөлтийн хувьд өөрчлөлт орсныг мөрдөн ажиллаж байна.

## **2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ**

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа, дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан болно.

Тус Соёлын өвийн үндэсний төвийн мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь Сангийн яамнаас хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Соёлын өвийн үндэсний төв нь санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд “Acolous” программ хангамж ашигладаг байна.

Соёлын өвийн үндэсний төвийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд дунд гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй байна.

## **2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал**

Аудитаар Соёлын өвийн үндэсний төвийн бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судлан, эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэллээ.

Аудитын төлөвлөлтийн үе шатанд 5 эрсдэлтэй асуудалд горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

## **2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар**

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2018 оны жилийн эцсийн тайлангийн нийт орлогыг сонгож, эрсдэлийн түвшинг “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд сонгосон 2018 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт орлогыг суурь үзүүлэлт болгон 608,269.6 мянган төгрөгөөс 1 хувиар тооцон 6,082.7 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлын түвшинг тооцсон суурь үзүүлэлт болон хувь хэмжээг өөрчлөх шаардлагагүй гэж үзэн 2019 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт орлогын 1 хувь буюу 8,035.8 мянган төгрөгөөр тооцсон болно.

## 2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд

Соёлын өвийн үндэсний төвийн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 182,062.9 мянган төгрөгөөр буюу 21 хувиар буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан авлага, урьдчилж гарсан зардал, үндсэн хөрөнгө, засгийн газрын оролцоо дансууд байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	/мянган төгрөг/		
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	-	-	-
Авлага	51,519.1	27,681.8	(23,837.3)
Урьдчилгаа	11,500.0	-	(11,500.0)
Бараа материал	127,172.5	160,887.0	33,714.5
Үндсэн хөрөнгө	696,733.9	516,293.8	(180,440.1)
<b>Нийт хөрөнгө</b>	<b>886,925.5</b>	<b>704,862.6</b>	<b>(182,062.9)</b>
Өр төлбөр	-	-	-
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	886,925.5	704,862.6	(182,062.9)
<b>Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн</b>	<b>886,925.5</b>	<b>704,862.6</b>	<b>(182,062.9)</b>

Авлага дансны үлдэгдэл буурсан нь төсөл хөтөлбөрийн Төрийн сангаас авах нэмэлт санхүүжилтийн авлага буурснаас шалтгаалжээ. Авлага дансны үлдэгдэлд ЮНЕСКО төсөл хөтөлбөрийн Төрийн сангаас авах нэмэлт санхүүжилтийн авлага байна.

Урьдчилгаа дансны эхний үлдэгдэл нь тайлант хугацаанд 7,200.0 мянган төгрөгийн Өмнөговь аймгийн каталог, 800.0 мянган төгрөгийн Археологийн арга зүйн гарын авлага, 3,500.0 мянган төгрөгийн СӨ-н улсын анхдугаар зөвөлгөөн эмхэтгэл орлогод авсантай холбоотойгоор буурсан.

Бараа материалын дансны үлдэгдэл өссөн нь хангамжийн материалын өсөлтөөс шалтгаалжээ. Бараа материалын дансны үлдэгдэлд ашиглалтгүй бараа материал байхгүй.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл буурсан нь тайлант хугацаанд байгуулсан элэгдлийн зардлаас шалтгаалжээ.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 704,862.6 мянган төгрөг болж 182,062.9 мянган төгрөгөөр буурсан нь тайлант үеийн үр дүнгээс шалтгаалжээ.

## 2.9. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн шууд захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Монгол Улсын 2019 оны төсвийн тухай хуульд зааснаар Соёлын өвийн үндэсний төв тайлант онд орлого төвлөрүүлэх төлөвлөгөө батлагдаагүй байна.

Тайлант онд Төсвийн шууд захирагчийн төсөл хөтөлбөрт зориулан урсгал зардалд

нийт 637,337.7 мянган төгрөгийг улсын төсвөөс санхүүжүүлэхээр батлагджээ.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 4.5-д харуулав.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 539,517.8 мянган төгрөг буюу 84.7 хувьтай байгаа нь тайлант үед орон тоо дутуу ажилласантай холбоотой байна.

**Нэмэлт төсөв:** Монгол Улсын Засгийн газар, БСШУСЯ хамтран соёлын биет бус өвийн жагсаалтанд бүртгэгдсэн өвийг хамгаалах чиглэлээр ЮНЕСКО-ийн санхүүжилтээр “Чулуун соёлын өв үндэсний хөтөлбөр”, “Монгол уртын дуу лимбэдэх уламжлах арга, битүү амьсгааг өвлүүлэн уламжлуулах, тогтворжуулах” төсөл хөтөлбөрөөс 187,868.7 мянган төгрөг, дээд шатны төсвийн захирагчаас 26,800.0 мянган төгрөг, үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 2,940.0 мянган төгрөг буюу нийт 217,608.7 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлжээ.

Үүнээс цалин, нийгмийн даатгалын шимтгэлд 22,938.0 мянган төгрөг, хангамж, бараа материалын зардалд 12,897.4 мянган төгрөг, эд хогшил худалдан авахад 15,525.1 мянган төгрөг, томилолтын зардалд 16,452.5 мянган төгрөг, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөрт 121,255.2 мянган төгрөг нийт 189,068.2 мянган төгрөгийг зарцуулж, үлдэгдэл 28,540.4 мянган төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлсэн байна.

## **2.10. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн**

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон 5 эрсдэл тодорхойлж, гүйцэтгэх үе шатанд нэмж эрсдэл тодорхойлоогүй бөгөөд нийт 5 горим сорил хэрэгжүүллээ.

Аудитаар нийт 13,153.8 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс ажилчдын цалингаас суутгасан ХАОАТатвар 12,290.3 мянган төгрөгийг санхүүгийн тайланд тусгасан боловч татварын тайланд зөрүүтэй тусгасныг аудитын явцад залруулав. Алдаа зөрчлийг давтан гаргахгүй байх 1 зөвлөмж өгч, менежментийн захидалд тусгалаа.

## **2.11. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал**

Төсөл хөтөлбөр хэрэгжиж байгаатай холбоотойгоор нэмэлт санхүүжилтийн гүйцэтгэлийг авч үзэх нь зүйтэй гэж үзлээ.

## **2.12. Шилэн дансны мэдээлэл**

Соёлын өвийн үндэсний төв нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан 137 мэдээллээс 131 мэдээлэл хугацаандаа байршуулж, 4 мэдээллийг хугацаа хоцроож, 2 мэдээллийг байршуулаагүй байна.

## **2.13. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт**

Өмнөх санхүүгийн тайлангийн аудитаар 1 зөвлөмж өгснөөс хэрэгжилт 100 хувьтай байна.

## **2.14. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл**

Бид Соёлын өвийн үндэсний төвийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

Залруулагдаагүй 863.5 мянган төгрөгийн алдаа, зөрчил нь бидний тогтоосон 6,082.7 мянган төгрөгийн материаллаг байдлын түвшнээс бага байгаа тул зөрчилгүй дүгнэлт өглөө.



### “Зөрчилгүй” дүгнэлт

Соёлын өвийн үндэсний төвийн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлт болон бусад илчлэл тодруулгыг холбогдох хууль, УСНББОУС-ын дагуу материаллаг байдлын хувьд үнэн зөв, бодитой илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

### 3. Менежментийн захидал

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга АДБОУС болон аудитын дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

#### 1. Татвартай холбоотой асуудал

##### 1.1. Илрүүлэлт:

Байгууллагын эзэмшлийн 6 тээврийн хэрэгслийн 863,5 мянган төгрөгийн Авто тээвэр болон өөрөө явагч хэрэгслийн албан татварыг төлөөд Татварын нэгдсэн сайтад тайлагнаагүй, авто тээвэр болон өөрөө явагч хэрэгслийн албан татвар төлөгчөөр бүртгүүлээгүй байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-т заасан "үнэн зөв байх, Татварын ерөнхий хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.1-д заасан "Анхан шатны баримт бүрдүүлэх, нягтлан бодох бүртгэлийг тогтоосон журам, нягтлан бодох бүртгэлийн стандартын дагуу, төлбөрийн баримтад үндэслэн хөтөлж, татварын тайланг санхүү, аж ахуйн үйл ажиллагааны тайлан тэнцэлд үндэслэн үйлдэх" гэсэн заалттай тус тус нийцэхгүй байна.

##### 1.2. Эрсдэл:

Татварын хууль тогтоомж зөрчигдөх;

##### 1.3. Өгсөн зөвлөмж:

Зөрчлийг дахин давтахгүй байх, тээврийн хэрэгслийг татвар төлөгчөөр бүртгүүлэх зөвлөмж өгөв.

##### 1.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

Аудитаар илэрсэн алдаа зөрчлийг хүлээн зөвшөөрч, дахин давтахгүй ажиллана.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2020 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

#### 4. Аудит хийсэн санхүүгийн тайлан

##### 4.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b><u>190,191,579.00</u></b>	<b><u>188,568,799.16</u></b>
<b>33</b>	<b>АВЛАГА</b>	51,519,097.00	27,681,812.80
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	127,657.00	00.00
<b>335</b>	<b>Бусад авлага</b>	51,391,440.00	27,681,812.80
3351	Байгууллагаас авах авлага	51,391,440.00	27,681,812.80
<b>34</b>	<b>УРЬДЧИЛГАА</b>	11,500,000.00	00.00
34600	Урьдчилж гарсан зардал	11,500,000.00	00.00
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	127,172,482.00	160,886,986.36
<b>354</b>	<b>Хангамжийн материал</b>	127,172,482.00	160,886,986.36
35410	Бичиг хэргийн материал	3,067,000.00	3,070,290.00
35420	Аж ахуйн материал	424,340.00	124,535.00
35430	Сэлбэг хэрэгсэл	320,000.00	320,000.00
35440	Түлш, шатах тослох материал	610,000.00	429,000.00
35450	Барилгын засварын материал	5,597,570.00	5,288,570.00
35470	Бусад хангамжийн материал	117,153,572.00	151,654,591.36
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b><u>696,733,890.42</u></b>	<b><u>516,293,751.34</u></b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	696,733,890.42	516,293,751.34
<b>392</b>	<b>Биет хөрөнгө</b>	573,107,956.00	397,831,706.40
39201	Барилга, байгууламж, орон сууц	10,000,000.00	10,000,000.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	-6,600,000.14	-8,600,000.18
39203	Авто-тээврийн хэрэгсэл	268,500,000.00	268,500,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-199,577,778.26	-233,886,111.74
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	1,482,277,944.48	1,492,305,944.48
39206	Хуримтлагдсан элэгдэл	-1,178,318,808.09	-1,307,133,205.47
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	263,776,292.03	263,776,292.03
39208	Хуримтлагдсан элэгдэл	-72,270,115.02	-93,956,972.72
39217	Ном	5,320,421.00	6,825,760.00
<b>393</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	123,625,934.42	118,462,044.94
39301	Програм хангамж	91,770,000.00	91,770,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-71,061,665.58	-76,225,555.06
39303	Бусад биет бус хөрөнгө	102,917,600.00	102,917,600.00
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b><u>886,925,469.42</u></b>	<b><u>704,862,550.50</u></b>
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b><u>886,925,469.42</u></b>	<b><u>704,862,550.50</u></b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	886,925,469.42	704,862,550.50
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	796,011,906.63	796,011,906.63
51101	Өмч: - төрийн	796,011,906.63	796,011,906.63
<b>512</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	90,913,562.79	-91,149,356.13
51210	Өмнөх үеийн үр дүн	90,913,562.79	90,913,562.79
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	-182,062,918.92
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b><u>886,925,469.42</u></b>	<b><u>704,862,550.50</u></b>

## 4.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>304,850,358.00</b>	<b>803,554,921.00</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>18,500,000.00</b>	<b>00.00</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	18,500,000.00	00.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	18,500,000.00	00.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	18,500,000.00	00.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>286,350,358.00</b>	<b>803,554,921.00</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	228,824,300.00	637,337,700.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	228,824,300.00	637,337,700.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	54,116,060.00	166,217,221.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	23,908,060.00	136,477,221.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	10,000,000.00	26,800,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	20,208,000.00	2,940,000.00
<b>1340</b>	<b>Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих</b>	3,409,998.00	00.00
134001	Нийгмийн даатгалын сангаас санхүүжих	3,409,998.00	00.00
<b>2</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>341,735,478.49</b>	<b>985,617,839.92</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>341,735,478.49</b>	<b>985,617,839.92</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	341,735,478.49	885,939,348.99
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	158,144,237.00	392,783,567.00
210101	Үндсэн цалин	113,418,682.00	282,102,827.00
210102	Нэмэгдэл	28,606,000.00	81,086,703.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	15,120,000.00	29,594,037.00
210104	Урамшуулал	999,555.00	00.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	19,183,708.00	55,853,226.13
210201	Тэтгэврийн даатгал	12,956,828.00	40,720,714.13
210202	Тэтгэмжийн даатгал	1,587,715.00	3,964,982.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,270,172.00	3,171,983.00

210204	Ажилгүйдлийн даатгал	306,271.00	689,298.00
210205	Эрүүл мэндийн даатгал	3,062,722.00	7,306,249.00
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	10,630,800.00	21,261,300.00
210304	Байрны түрээс	10,630,800.00	21,261,300.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	20,866,485.83	69,446,079.58
210401	Бичиг хэрэг	1,151,900.00	4,124,677.80
210402	Тээвэр, шатахуун	8,706,400.00	20,604,780.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,170,709.83	3,677,852.14
210404	Ном, хэвлэл	00.00	10,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	562,030.00	1,513,450.00
210407	Аж ахуйн материал худалдан авах зардал	8,275,446.00	39,515,319.64
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	59,840.00	375,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	59,840.00	375,000.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	6,154,440.00	9,639,190.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	1,630,000.00	1,018,500.00
210604	Урсгал засвар	4,524,440.00	8,620,690.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	1,816,000.00	21,840,900.00
210702	Дотоод албан томилолт	1,816,000.00	21,840,900.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	25,479,985.00	117,472,608.20
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	19,472,215.00	111,655,708.20
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	2,000,000.00	2,000,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	2,471,120.00	2,163,900.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	660,650.00	730,000.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	196,000.00	243,000.00
210807	Газрын төлбөр	680,000.00	680,000.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	99,399,982.66	197,267,478.08
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2,994,800.00	5,294,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	96,405,182.66	191,973,478.08
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	00.00	99,678,490.93
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	00.00	1,000,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	00.00	1,000,000.00
<b>2133</b>	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	00.00	98,678,490.93
213302	Засгийн газрын, Засаг даргын нөөц хөрөнгө	00.00	00.00

213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	00.00	98,678,490.93
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)</b>	<b><u>-36,885,120.49</u></b>	<b><u>-182,062,918.92</u></b>
<b>5</b>	<b>НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)</b>	<b><u>-36,885,120.49</u></b>	<b><u>-182,062,918.92</u></b>

### 4.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>		
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)</b>	<b><u>584,003,390.00</u></b>	<b><u>854,946,361.00</u></b>
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>584,003,390.00</b>	<b>854,946,361.00</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	457,480,500.00	637,337,700.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	457,480,500.00	637,337,700.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	126,522,890.00	217,608,661.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	85,093,890.00	187,868,661.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	17,221,000.00	26,800,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	24,208,000.00	2,940,000.00
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)</b>	<b><u>552,628,340.00</u></b>	<b><u>854,946,361.00</u></b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>552,628,340.00</b>	<b>854,946,361.00</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>481,569,280.33</b>	<b>727,586,057.27</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	315,241,338.00	392,783,567.00
210101	Үндсэн цалин	228,932,183.00	282,102,827.00
210102	Нэмэгдэл	55,069,600.00	81,086,703.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	30,240,000.00	29,594,037.00
210104	Урамшуулал	999,555.00	00.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	38,709,165.00	55,853,226.13
210201	Тэтгэврийн даатгал	26,109,031.00	41,897,898.23
210202	Тэтгэмжийн даатгал	3,219,865.00	3,552,783.84
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,575,893.00	3,110,672.00
210204	Ажилгүйдлийн даатгал	615,976.00	62,611.38
210205	Эрүүл мэндийн даатгал	6,188,400.00	7,229,260.68
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	21,261,300.00	21,261,300.00
210304	Байрны түрээс	21,261,300.00	21,261,300.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	19,421,767.33	23,392,288.94
210401	Бичиг хэрэг	4,118,210.00	2,949,630.00
210402	Тээвэр, шатахуун	10,006,400.00	14,432,780.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	4,059,097.33	3,805,339.94
210404	Ном, хэвлэл	00.00	1,516,839.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,238,060.00	687,700.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	1,429,940.00	1,411,500.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,429,940.00	1,411,500.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	10,063,540.00	23,018,390.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	2,566,100.00	11,302,700.00

210604	Урсгал засвар	7,497,440.00	11,715,690.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>3,289,000.00</b>	<b>18,984,900.00</b>
210702	Дотоод албан томилолт	3,289,000.00	18,984,900.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>64,653,620.00</b>	<b>185,901,385.20</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	58,586,600.00	180,084,485.20
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	2,000,000.00	2,000,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	2,471,120.00	2,163,900.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	669,900.00	730,000.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	246,000.00	243,000.00
210807	Газрын төлбөр	680,000.00	680,000.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>7,499,610.00</b>	<b>4,979,500.00</b>
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	7,499,610.00	4,979,500.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>71,059,059.67</b>	<b>127,360,303.73</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>800,000.00</b>	<b>1,000,000.00</b>
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	800,000.00	1,000,000.00
<b>2133</b>	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	<b>70,259,059.67</b>	<b>126,360,303.73</b>
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	70,259,059.67	126,360,303.73
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)</b>	<b><u>31,375,050.00</u></b>	<b><u>00.00</u></b>
<b>5</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)</b>	<b>31,375,050.00</b>	<b>00.00</b>
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>31,375,050.00</b>	<b>00.00</b>
<b>2200</b>	<b>Дотоод эх үүсвэрээр</b>	<b>31,375,050.00</b>	<b>00.00</b>
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	31,375,050.00	00.00
<b>6</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)</b>	<b><u>-31,375,050.00</u></b>	<b><u>00.00</u></b>
<b>8</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)</b>	<b>00.00</b>	<b>00.00</b>
<b>9</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	<b>00.00</b>	<b>00.00</b>
<b>10</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	<b>00.00</b>	<b>00.00</b>



#### 4.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2017 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	693,094,306.63	-	171,108,616.66	864,202,923.29
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	<b>693,094,306.63</b>	-	<b>171,108,616.66</b>	864,202,923.29
C07	Тайлант үеийн үр дүн	102,917,600.00	-	-80,195,053.87	22,722,546.13
D01	2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	<b>796,011,906.63</b>	-	<b>90,913,562.79</b>	886,925,469.42
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	<b>796,011,906.63</b>	-	<b>90,913,562.79</b>	886,925,469.42
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	-	-182,062,918.92	- 182,062,918.92
D09	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	<b>796,011,906.63</b>	-	<b>-91,149,356.13</b>	704,862,550.50

#### 4.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	637,337,700.00	539,517,829.07	(97,819,870.93)	84.7
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	637,337,700.00	539,517,829.07	(97,819,870.93)	84.7
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	636,337,700.00	538,517,829.07	(97,819,870.93)	84.6
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	463,636,600.00	378,768,221.00	(84,868,379.00)	81.7
210101	Үндсэн цалин	308,194,700.00	268,087,481.00	-40,107,219.00	87.0
210102	Нэмэгдэл	123,901,900.00	81,086,703.00	-42,815,197.00	65.4
210103	Унаа хоолны хөнгөлөлт	31,540,000.00	29,594,037.00	-1,945,963.00	93.8
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	57,954,600.00	46,930,554.13	(11,024,045.87)	81.0
210201	Тэтгэврийн даатгал	39,409,200.00	32,975,226.23	-6,433,973.77	83.7
210202	Тэтгэмжийн даатгал	4,636,400.00	3,552,783.84	-1,083,616.16	76.6
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,709,000.00	3,110,672.00	-598,328.00	83.9
210204	Ажилгүйдлийн даатгал	927,200.00	62,611.38	-864,588.62	6.8
210205	Эрүүл мэндийн даатгал	9,272,800.00	7,229,260.68	-2,043,539.32	78.0
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	21,261,300.00	21,261,300.00	-	100.0
210304	Байрны түрээс	21,261,300.00	21,261,300.00	00.00	100.0
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	11,758,700.00	10,494,888.94	(1,263,811.06)	89.3
210401	Бичиг хэрэг	2,000,000.00	1,999,630.00	-370.00	100.0
210402	Тээвэр, шатахуун	2,629,200.00	2,628,600.00	-600.00	100.0
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	4,966,000.00	3,662,119.94	-1,303,880.06	73.7
210404	Ном, хэвлэл	1,517,500.00	1,516,839.00	-661.00	100.0
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	646,000.00	687,700.00	41,700.00	106.5
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	1,430,000.00	1,411,500.00	(18,500.00)	98.7
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,430,000.00	1,411,500.00	-18,500.00	98.7
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	7,500,000.00	7,493,290.00	(6,710.00)	99.9
210604	Урсгал засвар	7,500,000.00	7,493,290.00	-6,710.00	99.9
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	3,000,000.00	2,532,400.00	(467,600.00)	84.4
210702	Дотоод албан томилолт	3,000,000.00	2,532,400.00	-467,600.00	84.4
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	64,796,500.00	64,646,175.00	(150,325.00)	99.8
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	58,979,600.00	58,829,275.00	-150,325.00	99.7

210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	2,000,000.00	2,000,000.00	00.00	100.0
210803	Даатгалын үйлчилгээ	2,163,900.00	2,163,900.00	00.00	100.0
210804	Тээврийн хэрэгслийн татвар	730,000.00	730,000.00	00.00	100.0
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	243,000.00	243,000.00	00.00	100.0
210807	Газрын төлбөр	680,000.00	680,000.00	00.00	100.0
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	5000000.00	4979500.00	(20,500.00)	99.6
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	5,000,000.00	4,979,500.00	-20,500.00	99.6
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	1000000.00	1000000.00	-	100.0
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	1,000,000.00	1,000,000.00	-	100.0
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,000,000.00	1,000,000.00	00.00	100.0
	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	637,337,700.00	539,517,829.07	(97,819,870.93)	84.7
<b>1310</b>	<b>УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	637,337,700.00	539,517,829.07	(97,819,870.93)	84.7
131001	Улсын төсвөөс санхүүжих	637,337,700.00	539,517,829.07	-97,819,870.93	84.7

#### 4.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Дансны код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл
<b>I</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>		<b>217,608,661.00</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>		<b>217,608,661.00</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>		<b>217,608,661.00</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>		<b>14,015,346.00</b>
210101	Үндсэн цалин		14,015,346.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>		<b>8,922,672.00</b>
210201	Тэтгэврийн даатгал		8,922,672.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>		<b>12,897,400.00</b>
210401	Бичиг хэрэг		950,000.00
210402	Тээвэр, шатахуун		11,804,180.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр		143,220.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>		<b>15,525,100.00</b>
210601	Багаж, техник, хэрэгсэл		11,302,700.00
210604	Урсгал засвар		4,222,400.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>		<b>16,452,500.00</b>
210702	Дотоод албан томилолт		16,452,500.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>		<b>121,255,210.20</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж		121,255,210.20
<b>2133</b>	<b>Олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>		<b>28,540,432.80</b>
213303	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, төвлөрүүлэх шилжүүлэг		28,540,432.80
<b>II</b>	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>		<b>217,608,661.00</b>
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>		<b>217,608,661.00</b>
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж		187,868,661.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		26,800,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого		2,940,000.00
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		

## 5. Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

Огноо: <b>2019-12-31</b>	Аудитын нэр: <b>Соёлын өвийн үндэсний төвийн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн</b>	Аудитын код: <b>САГ-2020/121/СТА-ТШЗ</b>
Шалгагдсан байгууллагын нэр: <b>Соёлын өвийн үндэсний төв</b>	Мянган төгрөгөөр	

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
			Нэр	Албан тушаал	Овог нэр
	1	2	3	4	5
1	Байгууллагын эзэмшлийн 6 тээврийн хэрэгслийн 863,5 мянган төгрөгийн АТБӨЯХАТатварыг төлөөд Татварын нэгдсэн сайтад тайлагнаагүй	863.5	Зөвлөмж	Захирал, нягтлан бодогч	Г.Энхбат Д.Мөнхцэцэг





